

ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

2022 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	1. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах	1.1. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах	2017 - 2026	Төсөл хөтөлбөрийн зардлаас дээрх үйл ажиллагаанд 500.000 төгрөг зарцуулсан.		Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран сум өрхийн эрүүл мэндийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, Насан туршийн боловсролын нэгжийн менежер, сургууль, цэцэрлэгийн эмч, нийгмийн ажилтан, хоол зүйч, сумын байгаль хамгаалагч зэрэг нийт 234 хүнд “Ус ба орчны эрүүл ахуй” сэдэвт чадавхжуулах сургалтыг 5 агуулгын хүрээнд зохион байгуулсан. “Хүн амын ундны усан хангамж нэмэгдүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр Баянхонгор сум, Өлзийт, Богд сумын 130 иргэнд ундны усны эрүүл ахуй, ус зөөвөрлөх, хадгалах саванд тавигдах шаардлага, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулахад оролцогчдын сургалтын өмнөх мэдлэг дунджаар 43.8 хувь байсан бол сургалтын дараах мэдлэг 83.6 хувь болж 39.8 болж нэмэгдсэн. Хавсралт : 3 файл	70%
2		1.2. Эрүүл, аюулгүй хүнсний тогтолцоог бүрдүүлэх замаар хүн амын эрүүл зохистой	2017 - 2026	НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр 17,3 сая төгрөг зарцуулсан.		Аймгийн Засаг даргын 2018 оны “Давс чихэргүй өдөртэй болох тухай” А/185 дугаар захирамжийг малчин -39 иргэн, төрийн албан хаагч -29 иргэн, 6-9-дүгээр ангийн нийт-78 сурагч нарт танилцуулан сар бүрийн 1-ний өдрийг “Давсгүй”, 15-ны өдрийг	100%

		<p>хооллолтыг дэмжиж, хүн амын дундах жингийн илүүдэл, амин дэм, эрдэс бодисын дутагдлыг бууруулах, эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах</p>		<p>Хамтрагч байгууллагуудаас "Сүүн-Ээж" ээжүүдийн гарын бэлгэнд 228.600 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>"Чихэргүй" өдөр болгон тэмдэглэх уриалгад нэгдүүлсэн. Мөн хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээллийг ашиглан эрүүл хүнс сонгон хэрэглэх, давсны хэрэглээг бууруулах сурталчилгааг эрүүл мэндийн пэйж хуудсаар иргэдэд сурталчилан 2500 хандалтыг авсан. Цэцэрлэг, ЕБС-ийн тогооч нарыг чадавхжуулах сургалтыг ШУТИС-ийн ҮТС, НҮБХС БШУГ, МХГ хамтран 04 дүгээр сарын 07-09, 11-13-ны өдрүүдэд зохион байгуулан, ЭМС-ын холбогдох тушаалуудыг танилцуулан, хоол тэжээл хүнсний аюулгүй байдлын чиглэлээр мэдээлэл хийж, сургалтад цэцэрлэг сургуулийн нийт 84 тогооч хамрагдан, оролцогчдын мэдлэг 40-90 хувь болж дунджаар 49.6 хувиар нэмэгдсэн. Хоол тэжээлийн бэрхшээл, жингийн алдагдалтай, өвчлөмтгий 06-23 сар хүртэлх насны хүүхдүүдийг эрүүлжүүлэх, жингийн алдагдлаас гаргах зорилгоор Хүүхдийн зуны сувиллын үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны 17 нэгжид зохион байгуулж 173 хүүхдийг хамруулсан. Түр сувиллын үйл ажиллагааг зохион байгуулснаар хүүхдүүдийн жин дунджаар 300 гр нэмэгдэн, эцэг эх асран хамгаалагчид хүүхдийн асаргаа, бие бялдрын хөгжил чийрэгжилт, хооллолтын талаар мэдлэгтэй болсон. НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр 17,3 сая төгрөг зарцуулсан. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 7 хоногийн хүрээнд Галуут сумын Эрүүл мэндийн төв, Цагаан-Овоо эмэгтэйчүүдийн эмнэлэг, ОСЭГ ХХК, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Баянхонгор дахь салбар, Баянхонгор телевизтэй хамтран хүүхдээ сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллож өсгөсөн 5 ээжийн сайн туршлагыг сурталчлан "Сүүн-ээж" нэвтрүүлгийг бэлтгэн цахим орчинд байршуулан 18000 удаагийн хандалт авсан.</p>	
--	--	--	--	--	--	--

					Хавсралт : 3 файл	
3		1.3. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бүрдүүлэх	2017 - 2026	-	Баянхонгор аймгийн хэмжээнд нийт тусгаарлан ажиглах байрыг 32 объектод 191 өрөөнд 526 орыг бэлдсэнээс Баянхонгор сумын хэмжээнд 7 байгууллагын 85 өрөөнд 219 ортой тусгаарлах байр, сумдад 25 объектод 106 өрөөнд 307 ортой тусгаарлах байрыг бэлтгэж ажилласан. 2021 онд "Ковид-19" вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын газартай хамтран 2 удаа хийж, өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг шуурхай төлөвлөн, бэлэн байдлыг хангаж ажилласнаар эрсдэлийн түвшинг 60 хувиар бууруулсан. 2022 оны байдлаар Ковид-19 халдварын тархалт буурсантай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй.	100%
4		1.4. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжихийг бүх салбар, түвшинд нэвтрүүлж, эрүүл мэндэд эрсдэл учруулах хүчин зүйлсийг бууруулах, эрүүл мэндийг бэхжүүлэх хүчин зүйлсийг нэмэгдүүлэх	2017 - 2026	Дээрх үйл ажиллагаанд Орон нутгийн төсвөөс 3.500.000 төгрөгийг зарцуулсан.	"Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилт 19 арга хэмжээний хүрээнд боловсруулан эхний 10 сарын хугацаанд төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. Мөн "Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын сургалтыг зохион байгуулж, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 27 ажилтан хамрагдаж, оролцогчдын мэдлэг 31.1 хувиар нэмэгдсэн. Аймгийн эрүүл мэндийн салбарын 134 эмч, ажилтныг хамруулсан спортын арга хэмжээг 7 дугаар сард Баян-Овоо сумд зохион байгуулсан. Нарны алхалтын үйл ажиллагааг 6 дахь жилдээ зохион байгуулж, Баянхонгор сумын хэмжээд нийт 8 удаагийн алхалтаар 42 байгууллагын 1297 алба хаагчийг хамруулан Баганат талбай-Оготонтой булаг гэсэн маршрутаар өглөөний алхалт хийж хэвшүүлсэн. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах аяныг зарласан Засаг даргын захирамжийг бүх	90%

					нэгжүүдэд хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	
5	1.5. Хүн амд эрсдэлт зан үйлээ өөрчлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах	2017 - 2026	Орон нутгийн төсөв 1.5 сая төгрөг		Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор 45 удаагийн танхимын сургалтыг 1-2 удаагийн давтамжтай 7500 иргэнд зохион байгуулж мэдлэгийн түвшин дунджаар 30-50 хувиар нэмэгдсэн. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Политехник коллежийн 123 оюутанд “Архи тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулан оролцогчдын мэдлэг 27.4 хувиар нэмэгдсэн. “Эрүүл иргэн - Эртэч баянхонгорчууд” аяны хүрээнд Сумын Засаг даргын тамгын газар, Баянхонгор сумын Ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд "Эрүүл агаар эм" нийтийн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, Баянхонгор сумын 213 ахмадуудын дунд “Гэр бүлийн шугаман бүжиг”, “Эрүүл мэндийн дасгал” тэмцээнийг зохион байгуулсан. Үүрэгтэй залуус төрийн бус байгууллага, Баянхонгор сумын засаг даргын тамгийн газар, Биеийн тамир спортын хороо, Жаргалтай амьдрал төвтэй хамтран өглөөний Баянхонгорчууд үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж Баасан гариг бүрийн өглөө 06:00-08:00 хооронд булаг дээр: Дасгал хөдөлгөөн, Өглөөний цай, 20 мин мэдээлэл хийх, бүлгийн ярилцлага зэргийг зохион байгуулан нийт 184 хүн хамрагдаж идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж, стрессээ удирдах, эрүүл зөв хооллолт, хөдөлгөөн эрүүл мэнд мэдээлэл авч, эрүүл идэвхтэй амьдралын дадлыг хэвшүүлсэн. Хавсралт : 1 файл	100%
6	1.6. Гэр бүл	2017 -	10,0 сая төгрөг		Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн	100%

	төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар эх, хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэх	2026			чиглэлээр давхардсан тоогоор 9380 хүн Нийслэлийн үндэсний эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөг танхим болон цахимаар хүргэж ажилласан. Аймгийн Засаг даргын 2016 оны 522 дугаар захирамжийн дагуу төрөх насны 24569 эмэгтэйчүүдтэй улирал тутам эрүүл мэндийн анхан шатны нэгжүүдээс цахим болон утсаар холбогдож, төрөх насны эмэгтэйчүүдийн нэрийн хяналтыг хэрэгжүүлж байна. Нийт төрөх насны эмэгтэйчүүдийн 51.6 хувь, зорилтот бүлгийн НҮЭМ эмэгтэйчүүдийн 85,6 хувь нь гэр бүл төлөвлөлтийн аргыг үр дүнтэй хэрэглэж байна. Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор жирэмснээс сэргийлэх 6 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн тендер зарлаж, 10 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.	
7	1.7. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр орон нутгийн түвшинд тогтвортой бүтэц бий болгон чадавхижуулах	2017 - 2026	-		Аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/197 дугаар захирамжаар “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулж, бүтэц, орон тоог баталсан. Нийгмийн эрүүл мэндийн төв нь одоогийн байдлаар 8 мэргэжилтэнтэй, анхан шатны 24 нэгжүүдэд орон тооны нийгмийн ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нийгмийн ажилтнуудыг 2022 онд “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтануудын чадавхыг сайжруулах нь” сургалт, “Нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах нь”, “Ковидын халдварын үеийн тандалт хийх арга зүй, тандагч бэлтгэх, чадавхжуулах нь” сэдэвт сургалтуудад бүрэн хамруулсан.	100%
8	1.8. Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхитэй	2017 - 2026	-		2022 оны 10 сарын байдлаар Баянхонгор аймгийн нийт хүн ам 89975 байгаагаас эхний 10 сарын байдлаар хүн амын нас хүйс эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд”	100%

		оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаварыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд нь тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх			<p>“Малчдын эрүүл мэндийг дэмжих”, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” уриан дор, “ЭМС-139 дүгээр тушаал”-аар эрт илрүүлгийн үзлэг ,Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аян, Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээ, Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөний хүрээнд тус тус урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 59666 иргэн буюу 66.3 хувийг хамруулсанаас 11057 өвчлөл илрүүлж 60 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн. 2022 оны 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд артерийн гипертензийн эрт илрүүлэгт үзлэгийн хамрагдалт 53.7 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдалт 57.6 хувь байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэгт үзлэгийн хамрагдалтын хувь буурсан байна. Артерийн гипертензийн эрт илрүүлэгийн үзлэгт нийт 22523 хүн хамрагдаж, үүнээс давтан үзлэгийн 454 хүнээс 173 буюу 38,1 хувь нь онош батлагдсан байна. Чихрийн шижингийн эрт илрүүлэгийн үзлэгт нийт 15868 хүн хамрагдсанаас давтан үзлэгт 25 хүн хамрагдсанаас 16 буюу 64 хувьд нь чихрийн шижин оношлогдсон байна. Аймгийн хэмжээнд нас баралтын 387 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 40 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 23,2 хувь нь эмнэлэгт нас барснаас 31,1 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн мөн үеэс /31.4/ буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	
9		1.9. Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль	2017 - 2026	-	<p>Аймгийн хэмжээнд Ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын хамрагдалт: I тунгийн хамралт 89,5 II тунгийн хамралт-84,5 III тунгийн хамралт-57,9 IV тунгийн хамралт-9,6% , Ковид-19 халдвараас сэргийлэх 5-11 насны хүүхдийн вакцины</p>	100%

		орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх			1-р тунд 508 хүүхэд хамрагдаж 13,7 хувь, 2-р тунд 255 хүүхэд-6,9% байгаа нь улсын дундажтай ойролцоо, аймгуудын дунджаас өндөр байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/512 дугаар тушаалын дагуу хийсэн томуугийн дархлаажуулалт 66.2% хамрагдалттай байна. Хавсралт : 1 файл	
10		1.10. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны түншлэлийг бий болгох	2017 - 2026	-	Эрүүл жаргалтай Баянхонгорчууд хүн амын зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг Аймгийн төвөөс алслагдсан хоёр сум болох Баян-Өндөр, Шинэжинст сумуудад “CITYMED” эмнэлэгтэй хамтран зохион байгуулан хөдөөгийн 1104 иргэнийг үзлэгт хамруулсан. -Аймгийн засаг даргын Тамгын газрын 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/253 дугаар захирамжийн хүрээнд зорилтот бүлгийн 240 өрхөд эрүүл мэндийн төвүүдтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулсан. -МАСАМ-II төслийн хүрээнд Баянхонгор аймагт загвар өрхийн эрүүл мэндийн төв байгуулах зорилтын хүрээнд “Оточномгон” өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон ажиллаж байна. -Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, хүлээн авах хэсэгт 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулсан. -Цар тахлын үед дайчлан ажиллуулахаар хувийн хэвшлийн эмнэлгүүдийн хүний нөөцийг татан ажиллуулах гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%
11	2. Эрүүл, аюулгүй	2.1. Эрүүл мэндийн	2017 -	-	Хөдөө сумдаас аймгийн төвд оршин суугчид,	100%

	<p>хүнсний тогтолцоог бүрдүүлэх замаар хүн амын эрүүл зохистой хооллолтыг дэмжиж, хүн амын дундах жингийн илүүдэл, амин дэм, эрдэс бодисын дутагдлыг бууруулах, эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах</p>	<p>тусламж үйлчилгээг алслагдсан нутгийн хүн ам, түр оршин суугчид, бүртгэгдээгүй шилжин суурьшигчид, эрэгтэй эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээтэй уялдуулан өрх, сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийн чирэгдлийг багасгах</p>	<p>2026</p>			<p>бүртгэлгүй шилжин суурьшигч 5500 орчим түр оршин суугчдад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг өрхийн эрүүл мэндийн 4 төвөөр дамжуулан харьяалал харгалзахгүйгээр үзүүлж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлэх шаардлагатай тохиолдолд 13А маягтыг өрхийн эрүүл мэндийн төвөөс илгээж хэвшсэн. Ялангуяа жирэмсэн эх, 0-5 насны хүүхдийн байнгын хяналтдаа авч, шаардлагатай амин дэм, олон найрлагат бичил тэжээлээр ханган ажилласан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн даатгалаас 4 багцын үйлчилгээгээр санхүүжин иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хувьд дурангийн мэс засал, үений хагалгааг орон нутагт шинээр нэвтрүүлснээр иргэдийн хот явах чирэгдлийг багасган, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аюулгүй, өртөг багатайгаар хүргэсэн. 10 сарын байдлаар дурангийн хагалгаанд 245, түнхний үе солих мэс засалд 2 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.</p>	
<p>12</p>		<p>2.2. Эрүүл мэндийн байгууллагыг өмчийн хэлбэрээс үл хамааран үйл ажиллагааны нэгдмэл байдлаар тусламж үйлчилгээ хүргэх тогтолцоог бий болгож, эмнэлэг хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх</p>	<p>2017 - 2026</p>	<p>-</p>		<p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/813 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлэгчийг шилжүүлэхдээ өвчтөн илгээх хуудсыг цахимаар илгээж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгээс 3-р шатлалын эмнэлэгт нийт 69 өвчтөн шилжүүлж тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлсэн.</p>	<p>100%</p>

	мэдээлэл солилцох үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах					
13	2.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь хүн төвтэй байж тусламж үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлэх	2017 - 2026	-		Магадлан итгэмжлэл бүхий 35 эрүүл мэндийн байгууллага байна. 2022 онд нийт 18 байгууллага магадлан итгэмжлэх хүсэлт ирүүлсэн. Давтан 17, анх 1 байгууллага орсон. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын жилийн дундаж нь 2.8, Чанарын хувь-70. Төрийн үйлчилгээг цахимжуулж, үйл ажиллагааг түргэн шуурхай хүргэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлийн систем” программ хангамжийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор 3, 5 дугаар сард 2 удаагийн давтамжтай цахим сургалтыг зохион байгуулж 35 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 250 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Танхимын удаагийн сургалтад 44 эрүүл мэндийн төвийн дарга хамрагдсан. Хавсралт : 4 файл	100%
14	2.4. Зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг	2017 - 2026	-		2022 оны 10 сарын байдлаар Баянхонгор аймгийн нийт хүн ам 89975 байгаагаас хүн амын нас хүйс эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд” “Малчдын эрүүл мэндийг дэмжих”, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” уриан дор, “ЭМС-139 дүгээр тушаал”-аар эрт илрүүлгийн үзлэг ,Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт	100%

		сайжруулж, байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлэн, сэргийлж болох өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулах			илрүүлэг үзлэг, Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аян, Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээ, Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөний хүрээнд тус тус урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 59666 иргэн буюу 66.3 хувийг хамруулсанаас 11057 өвчлөл илрүүлж 60 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн. 2022 оны 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд артерийн гипертензийн эрт илрүүлэгт үзлэгийн хамрагдалт 53.7 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдалт 57.6 хувь байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэгт үзлэгийн хамрагдалтын хувь буурсан байна. Артерийн гипертензийн эрт илрүүлэгийн үзлэгт нийт 22523 хүн хамрагдаж, үүнээс давтан үзлэгийн 454 хүнээс 173 буюу 38,1 хувь нь онош батлагдсан байна. Чихрийн шижингийн эрт илрүүлэгийн үзлэгт нийт 15868 хүн хамрагдсанаас давтан үзлэгт 25 хүн хамрагдсанаас 16 буюу 64 хувьд нь чихрийн шижин оношлогдсон байна.	
15		2.5. Эмнэлгийн яаралтай тусламжийн чанар, ээлтэй байдлыг сайжруулж, алслагдсан нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	2017 - 2026	Улсын төсөв 244,6 сая төгрөгийн мобайл технологи, 15,6 сая төгрөгийн яаралтай тусламжийн жишиг төв	Мобайл технологийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 100 хувь нэвтрүүлж, чадавхижуулах сургалтыг сумын эмч, статистик, бага эмч нарын бүрэлдхүүнтэй нийт 82 эмч эмнэлгийн ажилчдад зохион байгуулж мобайл технологийн багцийн үзлэг нийт үзлэгийн (27645) буюу 25 хувийг эзэлж байна. Баруун аймгийн зам дагуу сум болох Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийг яаралтай тусламжийн жишиг төв болгохоор ЭМЯ-ны 15,6 сая төгрөгний санхүүжилтээр яаралтай түргэн тусламжийн иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Хавсралт : 1 файл	100%
16		2.6. Анхан болон	2017 -	-	Нэгдсэн эмнэлэгт тус онд уламжлалт сэргээн засах	70%

		хоёрдахь шатлалд уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх төв байгуулах	2026			эмчилгээг нийт 2663, хэвтэн эмчлүүлэх тасгаар 396 иргэнд 18 эмчилгээний нэр төрлөөр үйлчилж байна. Уламжлалт эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, европ эмчилгээний чанарыг дэмжих, бэлтгэгдсэн хүний нөөцөө бүрэн ашиглах зорилгоор сумын ЭМТ-үүд 70 хувь уламжлалтын их эмчээр хангагдаад байна.	
17		2.7. Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, сувилахуйн брэнд үйлчилгээг бий болгох	2017 - 2026	-		СЭМТ, ӨЭМТ- үүд, Эван сувилахуйн төв нь эхний 9 сарын байдлаар 2285 иргэнд давтамжтайгаар гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлснээс ахмад настан-686, хөгжлийн бэрхшээлтэй -158, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ-63 иргэн байна. Нэгдсэн эмнэлгийн Арьс хөнгөвчлөх эмчилгээний тасагт химийн тариаг байнгын Портын судсаар хийх ажилбарын амжилттай нэвтрүүлэн 5 хүнд хийгдээд байна. Хими эмчилгээний үед судас гэмтэх, судасны үрэвсэл, хатуурлаас сэргийлэх, хөдөлгөөн хязгаарлахгүй, эмчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудад халдвар авах эрсдлийг бууруулахаас гадна судасны гадуур химийн эм тариа гарах хүндрэлээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Мөн нойргүйдлээс сэргийлэх монгол төөнө, хэвтрийн үйлчлүүлэгчийн байрлал солих асаргааны хэрэгсэл зэргийг тусламж үйлчилгээндээ нэвтрүүлж үр дүнг тооцон ажиллаж байна.	100%
18		2.8. Хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж	2017 - 2026	-		Хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаанд нэг болох хорт хавдрын байн эмчилгээг нэвтрүүлснээр 2 үйлчлүүлэгчид байн эмчилгээг хийж, үйлчлүүлэгчийн биеийн байдал сайжирсан, хавдрын	100%

		байгаа өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээнд түлхүү анхаарч тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах			үсэрхийлэл нэмэгдэхгүй эмчилгээ үр дүнтэй үргэлжилж байна. Хорт хавдрын тусламж үйлчилгээнд хүний нөөцийг мэргэшүүлэхээр Хавдрын эмч хими эмчилгээний олгох курст суралцаж байна. Мөн Компьютер томографийн шинжилгээг аймагтаа хийж эхэлснээр 420 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж, үйлчлүүлэгчдэд учрах хүндрэл чирэгдэл багасч, орон нутагтаа нарийн мэргэжлийн оношилгоо үйлчилгээ авах боломжийг бүрдүүлснээр эдийн засгийн хувьд хэмнэлт гарч байна	
19	3. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бүрдүүлэх	3.1. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх замаар антибиотикт нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлж, эмийн чанар, аюулгүй байдлын тандалт, судалгаа хийх тогтолцоог сайжруулан клиникийн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлэх	2017 - 2026	-	Харъяа эрүүл мэндийн байгууллагуудад “Антибиотикийн зохистой хэрэглээ” сэдэвт аян, “Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилт үүсэхээс сэргийлэх” нэг сарын аяны төлөвлөгөөний хэрэгжилт 95.0 хувьтай байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн нян судлалын лабораторийн антибиограммын судалгаанаас 2021 онд нийт 19197 шинжилгээг 6-8 төрлийн тэжээлт орчин ашиглан хийж Үүнээс : тасагт – 1447 сорьц, амбулатори – 17570 сорьц, антибиотик мэдрэг чанар нийт 1173 сорьцонд тавьсан. 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт 7375 шинжилгээг хийж тасагт - 1046 сорьц, амбулатори -6329 сорьц, антибиотик мэдрэг чанар нийт 456 сорьцонд тавьсан нь өмнөх онтой харьцуулахад 22.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь иргэдийн дунд антибиотикийн хэрэглээ буурсан үзүүлэлттэй байна.	100%
20		3.2. Эрүүл мэндийн байгууллагуудын статус, шатлал, зэрэглэлд нь	2017 - 2026	эм, эмнэлгийн хэрэгсэлд 2,175.0 сая төгрөг тоног төхөөрөмж,	Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	100%

		тохирсон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног, төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах		барилга байгууламж 5.5 тэрбум төгрөг зарцуулсан.		ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан салбарын хэмжээнд 11 сарын байдлаар нийт 2 тэрбум 175 сая төгрөгийн татан авалт хийж эм зүйн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85.0 хувьтай байна. Амин чухал эмийн хангамж 93.0 хувьтай байна. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын 90%-тай байна.	
21		3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг зохицуулах замаар зорилтот бүлгийн хангагдаагүй хэрэгцээг хангах	2017 - 2026	2,175 сая төгрөг		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг нэгдсэн журмаар зарлаж нэгдсэн нэг үнээр худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж байна.	100%
22	4. Хүн амд эрсдэлт зан үйлээ өөрчлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.	4.1. Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэн шаардлагатай мэргэжилтнээр хангах чиглэлээр хүний нөөцийг эрэлт хэрэгцээнд тулгуурлан төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	2017 - 2026	10 сая төгрөг		2022 оны байдлаар давхардсан тоогоор нийт 1183 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 87 чиглэлээр ажлын байрны сургалтанд хамрагдсан. 2022 оны нэн шаардлагатай мэргэжлээр төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад 6 чиглэлээр нийт 7 эмч, төрөлжсөн мэргэжлийн сургалтанд 8 чиглэлээр 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 5 чиглэлээр 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус суралцаж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын А/336 дугаар захирамжаар нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг сургахад 10 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөр Удирддагын чиглэлээр 2 мэргэжилтэн, Глобал Удирдагч их сургуульд 10 сувилагч суралцаж байна. Хавсралт : 2 файл	100%
23		4.2. Эрүүл мэндийн ажилтны харилцаа, хандлагыг	2017 - 2026	-		Эрүүл мэндийн харилцаа хандлага сайжруулах чиглэлээр давхардсан тоогоор 383 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд соен гэгээрүүлэх сургалтад	100%

		сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах, эрүүл мэндийн ажилтныг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, чадавхжуулах			хамрагдсан. 2022 оны байдлаар Жаргалант, Баянцагаан, Баянбулаг, Баянговь, Жинст, Баянлиг, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Хүрээмарал зэрэг 10 сумын эрүүл мэндийн төвийн ёс зүйн багийн үйл ажиллагаатай танилцан, багийн гишүүдэд арга зүйн зөвлөгөөг ажлын байранд өгч чадавхжуулсан. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны 2021 оны ажлын тайланг дүгнэж, 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, багийн гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
24		4.3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлд хамт олон, нутгийн захиргааны байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	2017 - 2026	Нийт санхүүжилт 493,0 сая төгрөг	Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулах замаар Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчдын үндсэн цалинг ажилласан жил, ажлын ачаалал, үр дүнг харгалзан 15-45 хувь хүртэл нэмэгдүүлэн олгож байна. Эрдэнэмонгол уурхайтай хамтран ажиллах гэрээний дагуу сар бүр 1 эмнэлгийн мэргэжилтэн ажиллуулдаг бөгөөд тухайн ажилтны үндсэн цалинг байгууллагаас, Эрдэнэмонгол уурхайгаас 1,300,000 төгрөгийн нэмэлт цалинг олгож 11 сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн 2 эмч, 8 сувилагч томилолтоор ажиллуулсан. “Сувилагч чамдаа баярлалаа” хандивын тоглолтын орлогоос 2 сувилагчид монгол гэрийн дулаалгын багцад хамрагдахад нь дэмжлэг болгон тус бүр нь 750,000 төгрөгний батламж олгосон. Салбарын хэмжээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 заалтаар 201 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 783,5 мянган төгрөг, 29.2 заалтаар 14 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 247,8 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон. Харьяа эрүүл	100%

					<p>мэндийн 23 байгууллага ажилчдын ажлын хувцас авахад 30.6 сая төгрөг зарцуулсан. 2022 онд төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад 6, төрөлжсөн мэргэжлийн сургалтад 7, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр тус тус суралцаж байна.</p> <p>Хавсралт : 2 файл</p>	
25	<p>5. Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар эх, хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэх</p>	<p>5.1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх, өрх, сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтэнд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг оруулах</p>	2017 - 2026	550,2 сая төгрөг	<p>Өрх, сумын ЭМТ-ийн санхүүжилтэнд ЭМД-ын санхүүжилтийг оруулах асуудал шийдэгдээд ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоол “Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” болон бусад эрхзүйн зохицуулалтын гарч 3 дахь жилдээ хэрэгжиж байна. Тус тогтоолын дагуу “ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ” хийгдэж сумын ЭМТ нь сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ, элэгний В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, урвдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, оношилгоо, шинжилгээ /Биеийн ерөнхий үзлэг, БЗДХ-ын илрүүлэг/ гэсэн тусламж үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд санхүүжилтийн 5.86 хувийг ЭМД-ын сангийн эх үүсвэрээр бүрдүүлж байна. Сумын ЭМТ-ийн 2021 оны төсөвт 118.5 сая төгрөгийн төсвийн зохицуулалт хийгдэж эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол, хог хаягдлын зардлыг нэмэгдүүллээ. ЭМДҮЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны “Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23-р тогтоолын дагуу сум, өрхийн 24 эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авахаар сумын ЭМТ-үүд 640.5 сая төгрөгийн даатгалын санхүүжилтийн гэрээ байгуулагдаж</p>	90%

					гүйцэтгэл 550.2 сая төгрөг буюу 85.9 хувь байна.	
26	5.2. Салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг эрүүл мэндийн салбарын технологийн үнэлгээ, салбарын тэргүүлэх чиглэл, хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд суурилан хэрэгжүүлэх	2017 - 2026	-		2020 оны 6 сард батлагдсан Эрүүл мэндийн салбарын 2020-2022 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөө нь нийт 113 арга хэмжээнээс 77 нь хэрэгжиж 68 хувь зорилтод түвшинд хүрсэн байна.	70%
27	5.3. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, чанар хяналт, шалгалт тохируулга, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн технологийн төлөвлөлтийг бий	2017 - 2026	-		Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 6-ны 493 дугаар журмын хүрээнд Шалгалт тохируулга баталгаажуулалт нь 2 жил тутамд 1 удаа хийгддэг бөгөөд “Ковид-19” цар тахлын улмаас 2021, 2022 онуудад хийгдээгүй. 2023 онд шалгалт тохируулга баталгаажуулалтад хамрагдах тоног төхөөрөмжийн судалгааг ЭМЯ, ЭМХТ-д тус тус хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	100%

		болгох					
28	7. Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаварыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд нь	7.1. Салбарын мэдээллийн технологийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах баг байгуулж, хувь хүн, байгууллагын эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах эрх зүйн баримт бичиг боловсруулах	2017 - 2026	-		Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой аливаа үйл ажиллагааг зохицуулах зорилготойгоор Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 11 сарын 11- ний өдрийн А/128 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам батлуулан гаргасан. Журмын хүрээнд: -“Дижитал Баянхонгор хөтөлбөрөөс зохион байгуулагдсан “Мэдээллийн аюулгүй байдал” 16 цаг, E-Mongolia академийн Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн орчин 4 цагийн хоёр төрлийн 20 цагийн сургалтад ЭМГ-1, Нэгдсэн эмнэлэг-2, Зөст-1 мэргэжилтнүүд хамрагдан “ЭМФАСОФТ” компанийн сертификатуудыг авсан. -Эрүүл мэндийн 26 байгууллагуудын компьютерыг вирусийн програмжуулах зорилтын хүрээнд нийт 158 нэг жилийн эрх худалдан авч суулган үйл ажиллагаандаа ашиглаж байна. Эрүүл мэндийн салбарын компьютерын 70 хувийг вирусийн програмжуулсан.	100%
29	тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх	7.2. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэд технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилээний чанар хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх	2017 - 2026	244,6 сая төгрөг		Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хөрөнгө оруулалтаар эрчимт эмчилгээ, хүүхэд, төрөх, эмэгтэйчүүдийн тасагт телемедицинский тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан дээд шатлалын эмнэлгүүдээс 11 сарын байдлаар 52 удаагийн зөвлөгөө үйлчилгээ авсан байна. Сум өрхийн 20 эрүүл мэндийн төв мобайл технологийн иж бүрэн 244.6 сая төгрөгийн үнэ бүхий төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 100% хангагдаж эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж байна. Энэ онд нийт мобайл технологийн төхөөрөмжийг ашиглан 57365 үзлэг хийгдсэн байна.	100%

30		8.1. Орон нутгийн өмчит эмнэлгийг хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалтай болгох	2017 - 2026	-		Эрүүл мэндийн газрын бүтэц батлах тухай 2021 оны аймгийн Засаг даргын А/38 дугаар захирамжаар “Нийгмийн эрүүл мэндийн төв” бүтэцтэйгээр, 12 орон тоотой, анхан шатны эрүүл мэндийн 24 нэгжид нийгмийн эрүүл мэндийн ажилтан бүтэн орон тоогоор ажиллаж байна.	100%
31	8. Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	8.2. Эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газарзүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах	2017 - 2026	-		2022 онд Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 119 аж ахуйн нэгж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс 5 удаа хуралдаж, давхардсан тоогоор 29 аж ахуйн нэгжийн асуудал хэлэлцэн аймгийн Засаг даргын захирамжаар шинээр шүд, дүрс оношилгоо, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 3 клиник эмнэлэгт, Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх чиглэлээр 1, эмийн сангийн чиглэлээр 2 аж ахуйн нэгжид олгож, сунгалт 6, хүчингүй болгосон 7, түдгэлзүүлсэн 3, бусад 4 хаягийн өөрчлөлт хийж ажилласан. Хавсралт : 5 файл	100%
32		8.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэдийг хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хамтын үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	2017 - 2026	-		Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 119 эрүүл мэндийн байгуулагаас: Улсын 21, ӨЭМТ-4, хувийн хэвшлийн ор бүхий эмнэлэг 8, клиник эмнэлэг-31, Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх байгуулага-4, сувилал-2, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгуулага-5, эмийн сан-45 эрүүл мэндийн салбарт хамтын үйл ажиллагаатай явуулж байна. 2022 оныг “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил”-ийн хүрээнд Эрүүл мэндийн Чанарын холбоо, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй	100%

					хамтран 2 удаагийн 4 өдрийн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулж 120 аж ахуй нэгжийн 370 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, тусламж үйлчилгээний чанарын нэгдсэн нэг ойлголттой болсон. Сумын эмийн санг аж ахуйн тооцоот үйл ажиллагаанд шилжүүлэн, Сумын ИТХ, ЭМГ, Эрүүл мэндийн төв, Эмийн сангийн хооронд хамтран ажиллах дөрвөлсөн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд Эрүүл мэндийн газраас хяналт тавин ажиллаж байна.	
33	8. Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	8.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх	2017 - 2026	-	Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудад албан бичгээр мэдээлэл хүргэн, Ковид 19 халдварын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд аймгийн онцгой комисстой хамтран ажилласнаар нийт иргэдийн 89,5 хүртэл хувь, 5-11 насны хүүхдийн 13,7 хувийг сайн дурын вакцинд хамруулсан нь аймгуудын дундажтай харьцуулахад хамралт сайн байгааг ХӨСҮТ цохон тэмдэглэсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг эмнэлгийн тусламж үйлчилгээний хуулийн дагуу зохион байгуулж, төлөөлөлд төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцон, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.	100%